

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 447

Арвайхээр сум

Г Магадлан итгэмжлэлийн зөвлөн  
туслах баг байгуулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн “Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх журам батлах тухай” А/503 дугаар тушаалаар батлагдсан хавсралт журмын 2.5, 2.5.2, 2.5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэлийн зөвлөн туслах багийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх журам батлах тухай” А/503 дугаар тушаалаар батлагдсан журмын 2.5 дахь хэсэгт заасан чиг үүргийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний хэлтсийн дарга (Ю.Ичинноров)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Я.Жаргал)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” а/29 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ОЮУНТУЯА



Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны  
09 сарын 24-ны өдрийн дугаар  
тушаалтын нэгдүгээр хавсралт

## МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ЗӨВЛӨН ТУСЛАХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч: Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний хэлтсийн дарга

Гишүүн: Хүүхдийн тусlamж үйлчилгээ, магадлан итгэмжлэл хариуцсан  
Мэргэжилтэн

Халдварт өвчин, бэлгийн зам, эмнэлгээс шалтгаалах, цусаар  
дамжих болон гэдэсний халдварын тандалт сэргийлэлт  
хариуцсан мэргэжилтэн

Эмнэлгийн тоног төхөөрөмж хариуцсан мэргэжилтэн

Сувилахуйн тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Төрийн бус байгууллагын төлөөлөл